

БАТЛАВ:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.ГАНБААТАР

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ,
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН
УДИРДАМЖ**

2023 оны 5 сарын 31-ний өдөр

1.Зорилго: Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт,захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нийтлэг журмыг хэрэгжүүлэх аргачлал"ын дагуу бодлогын баримт бичгийн төлөвлөлтөд хяналт-шинжилгээ хийж, зөвлөгөө өгөх.

2.Хугацаа: 2023 оны 6 дугаар сарын 05-наас 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрүүдэд багтаан явуулна.

3.Ажиллах багийн бүрэлдэхүүн:

Хяналт-шинжилгээ,үнэлгээний

хэлтсийн дарга:

Ц.Ганчимэг

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн мэргэжилтэн:

Б.Ундрахжаргал

4.Хамрах хүрээ: Баянхутаг, Галшар, Баянмөнх, Дархан, Дэлгэрхаан, Бор-Өндөр, Жаргалтхаан, Мөрөн, Цэнхэрмандал сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, мэргэжилтнүүд хамрагдана.

5.Хяналт- шинжилгээнд хамрагдах асуудлын чиглэл:

1. Бодлогын баримт бичгийн төлөвлөлт
2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төлөвлөлт
3. Сумдын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө
4. Мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдаа, төлөвлөлт

- Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоол болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар баталсан журам, аргачлалын дагуу үнэлж дүгнэн үнэлгээ өгнө.

- Ажлын хэсгийг ажиллах үед хяналт-шинжилгээнд хамрагдах асуудлаа бүрэн хамруулж хариуцсан албан хаагчаа бэлэн байлгаж оролцуулахыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

- Хяналт-шинжилгээний дүнг удирдлагын зөвлөлд ажлын 7 хоногт багтаан танилцуулна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС